



УНШЖЛАХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2015 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/227

Улаанбаатар хот

Төлбөрт үйлчилгээний журам, төлбөрийн
хэмжээг батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь заалт, Ректорын зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, багш, ажилтан, суралцагчдад чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх, төвийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. ШУТИС Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх төлбөрт үйлчилгээний журмыг нэгдүгээр хавсралтаар, тусламж үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс мөрдсүгэй.


2. Эрүүл мэндийн тусламж-үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай, төгтсөн-стандарт шаардлагыг бүрэн хангаж чанартай явуулах, энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн нийт эмч, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3. Төлбөртэй үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Ц.Ононтуул/, төсөв санхүүгийн журмын дагуу бүртгэж тайлагнаж байхыг Санхүү эдийн засгийн албаны дарга /Ц.Бумцэнд/, бүрэлдэхүүн сургуулийн ахлах нягтлан бодогч, кассын нярав нарт даалгасугай.

4. Төлбөртэй тусламж үйлчилгээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, тухайн жилийн орлогын тодорхой хувийг эмч эмнэлгийн ажилтаны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах болон хэрэгцээт материал, багаж тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулахыг Эдийн засаг, нийгмийн хөгжил эрхэлсэн проректор /Д.Батчулуун/, Хангамж үйлчилгээний албаны дарга /Б.Очир/ нарт даалгасугай.


5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ректорын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А-12 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын сургуулийн эмчийн төлбөртэй үйлчилгээ хэсгийг хүчингүй болгосугай.

РЕКТОР



Б.ОЧИРБАТ

ШУТИС-ийн Ректорын 2015 оны 10-р сарын 21-ны
өдрийн ~~A/227~~ тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвөөс суралцагч, оюутан, багш, ажилчдад /иргэд/ зарим тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төлбөртэй тусламж үйлчилгээ гэдэгт Ректорын 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн ~~A/227~~ тоот тушаалын хоёрдугаар хавсралтад заасан тусламж үйлчилгээ хамаарна.

1.3. Суралцагч, оюутан, багш, ажилчид /иргэд/ үйлчилгээний төлбөрөө бүрэлдэхүүн сургуулийн кассанд төлж, төлбөрийн баримтыг эмчид өгч үйлчилгээ авна.

Хоёр. Төлбөртэй үзүүлэх тусламж үйлчилгээний орлогыг хураах, тайлагнах

2.1. Эрүүл мэндийн төвөөс үзүүлж буй тусламж үйлчилгээний үнэ тарифыг сургуулийн цахим хуудас, эрүүл мэндийн төвийн мэдээлэлийн самбар болон бүрэлдэхүүн сургуулиудын эмнэлэг, бэлэн мөнгө хураах касс, эмч нарын өрөөнд үйлчлүүлэгчид харагдахуйц ил тод байршуулсан байна.

2.2. Кассын нярав үйлчлүүлэгчийн мөнгийг хурааж авахдаа төв болон бүрэлдэхүүн сургуулийн эмнэлэг аль нь болохыг заахын хамт үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр нь төлбөрийн хэмжээг бичиж тэмдэглэн, үйлчлүүлэгчээр гарын үсэг зуруулж тэмдэг дарж баталгаажуулсан баримт олгож байна.

2.3. Үйлчлүүлэгчийн төлбөртэй үйлчилгээнд төлсөн бэлэн мөнгийг хураан авсан кассын нярав ШУТИС-Захиргаа Голомт банк 1102928177 тоот төгрөгийн дансанд тухайн өдөрт нь багтаан шилжүүлэх бөгөөд ахлах нягтлан бодогч орлогыг байгууллагын санхүүгийн программд бүртгэнэ.

Гурав. Хориглох зүйл

3.1. Яаралтай болон гэнэтийн осол гэмтлийн тусламж үйлчилгээ, анхны тусламжийг төлбөртэй үзүүлэхийг хориглоно.

3.2. Эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүд суралцагч, оюутан, багш, ажилчдаас тусламж үйлчилгээний төлбөрийг шууд бэлэн мөнгөөр тооцоо хийж авахыг хориглоно.


3.3. Эмч эмнэлэгийн мэргэжилтэн ажлын байрандаа хувийн журмаар нэмэлт төлбөрт үйлчилгээ эрхлэх, эм биобэлдмэл, биологийн идэвхт бодис сурталчлах, худалдан борлуулахыг хориглоно.

3.4. Эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдээс бие засах газар, нөмрөг, халатны үнэ, хувцас өлгөх гэх мэт нийтлэг зүйлээс төлбөр авахыг хориглоно.

3.5. Тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай стандарт эмчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл, материалыг суралцагч, оюутан, багш, ажиллагсадаар олуулахыг хориглоно.

ШУТИС-ийн Ректорын 2015 оны 10-р сарын 21-ны
өдрийн 227 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Дөрөв. Бусад



4.1. Энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагааг эрхэлсэн албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд Эрүүл мэндийн тухай хууль болон хөдөлмөрийн хууль холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж хохирлыг буруутай этгээдээр бүрэн төлүүлнэ.

ШУТИС-ийн Ректорын 2015 оны 10-р сарын 21-ны өдрийн А/222 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Нөхөн сэргээх физик эмчилгээний үнэ тариф

№	Эмчилгээний нэр	Эмчилгээ		Курс эмчилгээ	
Бариа засал					
1	Толгойн бариа	1 удаа	2000	3 удаа	6000
2	Хэсгийн бариа	1 удаа	2500	3 удаа	7500
3	Хүзүү сэргээний бариа	1 удаа	5000	5 удаа	25000
4	Бүх биеийн бариа	1 удаа	20000	6 удаа	100000
5	Нүүрний цэгэн бариа	1 удаа	5000	7 удаа	35000
Засал эмчилгээ					
6	Банк	1 удаа	500	3 удаа	1500
7	Гулгуур банк	1 удаа	1000	5 удаа	5000
8	Нурууны татлага	1 удаа	2000	10 удаа	20000
9	Хүзүүний татлага	1 удаа	2000	10 удаа	20000
10	Зөгийн балтай татлага	1 удаа	1000	3 удаа	3000
11	Чихний төөнүүр	1 удаа	10000	3 удаа	30000
12	Төөнүүр	1 удаа	1000	5-7 удаа	5000
13	Шивүүр	1 удаа	5000	5-7 удаа	30000
14	Бичил хануур	1 удаа	2000	3 удаа	6000
15	Самнуур	1 удаа	15000	10 удаа	100000
16	Зүү	1 удаа	2000	7 удаа	14000
Цахилгаан эмчилгээ					
17	Толгойн массаж	1 удаа	1000	5 удаа	5000
18	Хүзүүний массаж	1 удаа	500	3-5 удаа	2500
19	Орны массаж	1 удаа	1000	3-5 удаа	5000
20	Цахилгаан зүү	1 удаа	3000	7 удаа	21000
21	Цахилгаан массаж	1 удаа	500	3-5 удаа	2500
22	Хаш чулуун ор	1 удаа	1000	5 удаа	5000
23	Парафин /жижиг, дунд, том/	1 удаа	3000	7-10 удаа	21000-30000
24	УВЧ	1 удаа	1000	3-5 удаа	5000
25	Электрофорез	1 удаа	2500	3-5 удаа	12500
26	Искра	1 удаа	1000	3-5 удаа	5000
27	Инфра ред	1 удаа	1000	3-5 удаа	5000
28	Утлага эмчилгээ	1 удаа	1000	5 удаа	5000
Эмчилгээ, дасгал хөдөлгөөн					
29	Хүчилтөрөгчийн коктейль	1 аяга	500	10 удаа	5000
30	Чийрэгжүүлэлт явган аялал	1 удаа /хүн/	1000	1-2 удаа	2000

ШУТИС-ийн Ректорын 2015 оны 10-р сарын 21-ны
 едрийн 7/227 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Шүд, амны хөндийн эмчилгээний үнэ тариф

№	Эмчилгээний төрөл	Үнийн тариф
1	Эмчийн үзлэг, оношлогоо	
	Амны хөндийн нийт шүдийг багажаар оношлох	1000
	Амны хөндийн нийт шүдийг дэлгэцээр оношлох	Төлбөргүй
	Амны хөндийн нийт шүдийг рентген зургаар оношлох	Төлбөргүй
2	Зөвөлгөө	Төлбөргүй
3	Шүдний урьдчилан сэргийлэх эмчилгээ	
	Байнгын шүдийг цоорлоос сэргийлэх фтортын найрлагатай ховил битүүлэх ломбо /1 шүд/	3000
	Байнгын шүдийг цоорлоос сэргийлэх фторт лак түрхэх 1 шүд /курс эмчилгээ 7 хоногт 2 удаа, жилд 2-3 удаа давтах/	500
	Saforiade /Сүүн шүдний цоорол/	1000
	Шүдний цэвэрлэгээ шүдний өнгөр арилгах бүх шүд /кофе, тамхины өнгөр	20000
	Аппараттай шүдний цэвэрлэгээ	2500
	Шүдний наалт	1500
4	Байнгын шүд ломбодох	
	Өнгөц цоорол	18000
	Дунд цоорол	20000
	Гүн цоорол	22000
5	Амны хөндийн мэс ажилбар	
	Сүүн шүд авах	5000
	Байнгын шүд авах	8000
	Хөдөлгөөнтэй шүд авах	4000
	Мэдээ алдуулалт	1000
	Шүд авсан ором цэвэрлэх	500
6	Буйл ба шүдний тулгуур эдийн үрэвслийн эмчилгээ	
	Шүдний чулуу цэвэрлэх /1шүд/	1000
	Буйланд эм тавих, шавшлага хийх /1 удаа/	1500
7	Цоорлын бус гаралтай эмгэгийн эмчилгээ	
	Шүдний хатуу эдийн хэт мэдрэгшилтэнд түрхлэг түрхэх	2000
8	Шүд цайруулах	
	Эмнэлгийн цайруулалт /курс 3-4 удаа/	250000
9	Сувгийн эмчилгээ	
	Мэдээ алдуулах	1500
	Мишъяак тавих	1500
	Шүдний хөндий нээх	1500
	Суваг өргөсгөх, цэвэрлэх/нэг суваг/	1000
	Шүдний сувгийн эм солих/давтан/	500
	Шүдний суваг ломбодох/нэг суваг/	1500
	Сувгийн хуучин ломбо авах	4000

ШУТИС-ийн Ректорын 2015 оны 10-р сарын 21-ны
 өдрийн А/202 тоот тушаалын хоёрдугаар хавсралт


Дүрс оношлогооны үнэ тариф

№	Шинжилгээний нэр	Үнэ төгрөг
1	Нэг удаагийн хэвлийн эхо	10000
2	Зүрхний бичлэг	5000

Урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээний үнэ тариф

№	Үйлчилгээ	Үнэ тариф	Тайлбар	
1	Шинээр элсэгч, дотуур байрны болон үйлдвэрлэлийн дадлагад гарах оюутнуудын урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг	10000	Зүрх судас, Дотор, Мэдрэл, Нүд, Чих хамар хоолой, Шүд амны хөндий, Арьс БЗХӨ, Эмэгтэйчүүд, Халдварт сүрьеэ	
2	Тариа	Дусал	1000	Өрхийн эмч, II, III шатлалын эмчийн заалтаар хийлгэх үйлчилгээ
		Судас тариа	300	
		Булчин тариа	500	
		Арьсан доорх тариа	500	
		Сорил тариа	500	
		Анхны тусламжийн үйлчилгээ	Төлбөргүй	
3	Өндөр, жин үзэж БЖИ тодорхойлох	Төлбөргүй		
4	Их эмчийн үзлэг, оношлогоо	Төлбөргүй		
5	Их эмчийн зөвөлгөө	Төлбөргүй		
6	Сахар хэмжих	1500		

ШУТИС-ийн Ректорын 2015 оны 10-р сарын 21-ны өдрийн 7227 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Амралт, сувилалын төвийн түр үнийн тариф

№	Эмчилгээний төрөл	Сувилалын эрхтэй бичигтэй багш, ажилчид	Сувилалын эрхийн бичигтэй гадны хүмүүс	Сувилалын эрхийн бичиг аваагүй багш, ажилчид
1	Эмчийн үзлэг			Төлбөргүй
2	Оношлогоо			
3	Зөвөлгөө			
4	Дусал тариа			
5	Булчин тариа			
6	Судас тариа			
7	Арьсан доорхи тариа			
8	Сорил тавих			
9	Эмчилгээний дасгал хөдөлгөөн			
10	Хэсгийн бариа			
11	Физик эмчилгээ	35000-40000	60.000-80.000	УВЧ
				Инфра
				Татлага /хүзүү, нуруу/
				Искра
				Электрофорез
				Бумба
				Гулгуур бумба
				Цахилгаан төөнө
				Давсан зам
				Элсэн шарлага
				Зөгийн балтай татлага
12	Анхны тусламж			Артерийн даралт үзэх
				БЖИ
				Өндөр, жин хэмжих
				Боолт /Цэвэр/
				Яаралтай тусламжийн эм тариагаар 1 удаа үйлчлэх
13	Бүх биеийн зөөлөн бариа	15.000	15.000	25000
14	Сүүн /тосон, шар сүүн/ бариа засал	15.000	15.000	25000
15	Парафин	2.000	2.000	3000
16	Хануур	20.000	20.000	25000
17	Самнуур	15.000	15.000	20000
18	Шивүүр	15.000	15.000	20000
19	Зүү	2.000	2.000	3000
20	Утлага /эмтэй/	2.000	2.000	2500